



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 0/218

Арвайхээр

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон Улсын Хараагүйчүүдийн Спортын холбооноос Казакстан Улсын Астана хотод 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулагдах пара жүдо бөхийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин Г.Чулуунсүхийн замын зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг, Өмнөд Африк Улсад 2023 оны 5 дугаар сарын 20-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Хэвтээ шахалт”-ын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн оролцох Э.Мөнхбаярын замын зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 2,000,000 (хоёр сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0405